



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 454

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 41,042,400.00 (дөчин нэгэн сая дөчин хоёр мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ, 28,989,799.86 (хорин найман сая есөн зуун наян есөн мянга долоон зуун ерэн есөн төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Прокурорын газрын дүүргийн Ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ц.Ариунболд, Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Р.Нямчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000878

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
 454 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРААС "БАНУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
 КОМПАНИЙН БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон ОН	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ниссан Теанна, 05-29 УБУ, LGBF1AE048R013534, Суудлын автомашин	2007/2008	139597	41,042,400.00	28,989,799.86	12,052,600.14
НИЙТ ДҮН				41,042,400.00	28,989,799.86	12,052,600.14 (арван хоёр сая тавин хоёр мянга зургаан зуун төгрөг арван дөрвөн мөнгө)
				(дөчин зургаан сая есөн зуун мянган)	(дөчин зургаан сая есөн зуун мянган)	